

## МОНГОЛ, ЯПОНЫ ХАРИЛЦААНЫ ТҮҮХИЙГ ЭРГЭН ХАРАХУЙ ХИЙГЭЭД ХОЁР ОРНЫ БҮХ ТАЛЫН ТҮНШЛЭЛИЙН ХАРИЛЦАА

*Э.Наран\**

### **Монгол, Японы харилцааны түүхийг эргэн харах нь**

Дэлхийн I дайнаас өмнө, Японы горьдлого бол Монголын бүс нутаг байлаа. 1913 онд Японы түшмэл Монголд ирж дотоод, гадаад Монголыг Хятадаас салгахыг санаархаж байсан ч, Хаант Орос хөндлөнгөөс оролцсоны улмаас чадаагүй юм. 1927 оны 7-р сард Японы ерөнхий сайд Танака эзэн хаандаа өргөн барьсан “Эзэнт улсаас Манжуур, Монголд явуулах үндсэн бодлого” айлтгал бичигтээ: “Хятадыг эзлэн авахыг хүсвэл эхлээд Манжуур, Монголыг эзлэх ёстой, дэлхийг байлдах дагуулахыг хүсвэл эхлээд Хятадыг эзлэх хэрэгтэй” гэж ил тод зарласан юм. Эндээс “Манжуур, Монгол”-ыг эзлэн түрэмгийлэх гэсэн балмад төлөвлөгөө үндсэндээ бий болсон байна. 1939 оны 5-р сард Япон улс Халх голд дайн дэгдээж, Монгол Улсад түрэмгийлэн халдаж улмаар Зөвлөлтийн Алс Дорнодын бүс нутагт дайн өдөөх “умардал довтлох төлөвлөгөө”-гөө бодитойгоор хэрэгжүүлэх болов. ЗХУ Японы энэхүү санаархлыг мэдэж байв. Тэгээд 1939 оны 8-р сарын 20-нд Зөвлөлт, Монголын хамтарсан арми ердөө 10 хоногт Японы армийг бутцохисон юм. Ингэж бут ниргэсний дараа, Япон улс өөрийгөө ийм хүчирхэг ЗХУ-ын хуурай замын цэрэгтэй газрын тулалдаан хийх үндсэн хүчин чадалгүйгээ мэдэрсэн юм.

Иймээс энэхүү дайн нь дэлхийн 2-р дайны үйл явцад хүчтэй нөлөөлсөн, Хятадын ард түмний Японыг эсэргүүцэх дайнд ч Японы армийн хүчийг хязгаарлахад хүргэж Хятадын Японы эсрэг дайнд идэвхтэй дэмжлэг болсон юм.

1945 оны 8-р сарын 8-нд ЗХУ Японд дайн зарлаж, 8-р сарын 10-нд Монгол Улс Японы эсрэг дайн зарласан ба Япон улс дайны байдалд орж, Монгол Улсын морьт механикжуулсан бүлэг /22-р морин ба явган цэргийн нэгтгэлийн 3 батальон, тагнуулын 1 анги/ Японы эсрэг дайнд орсон юм. Зөвлөлт, Монголын хамтарсан армийн явган цэргүүд Хятадын зүүн хойт Хятад, Өвөр Монгол, Хятадын ард түмний хамтаар Японы Квантуны армийг бутцохиж Японы милитаризмыг үг дуугүй бууж өгөх явдлыг түргэтгэн, фашизмыг эсэргүүцсэн дэлхийн дайны хамгийн сүүлчийн ялалтанд хувь нэмрээ оруулсан юм.

\* Э.Наран - БНХАУ-ын ӨМИС-ийн Хөрш орон судлалын хүрээлэн, доктор, профессор

1956 оноос хойш Монгол-Японы харилцаа эхэлсэн. 1957 оны 10-р сард Монгол Улс Япон-Хятадын худалдааг ахиулах нийгэмлэгтэй Бээжин хотноо Монгол-Японы худалдааг ахиулах албан мэдээг нийтэлсэн байна. 1959 оны 8-р сард Монголын Гадаад худалдааны яамны импорт-экспортын товчоо ба Японы олон улсын худалдааг ахиулах нийгэмлэгтэй 1960 онд харилцан бараа нийлүүлэх протоколд гарын үсэг зуржээ. 1963 оны 5-р сард Монгол-Японы жуулчны бүлэг харилцан солилцох хэлэлцээрт гарын үсэг зурав. 1968 оны 10-р сард Монгол-Японы нийгэмлэг байгуулагдаж, мөн оны 3-р сард Монгол, Японы хооронд 3 жилийн хугацаатай худалдааны хэлэлцээрт гарын үсэг зурлаа. 1970 оны 8-р сард Монголын Сайд нарын Зөвлөлийн орлогч дарга Д.Гомбожавыг Токио хотноо Японы гадаад хэргийн сайд хүлээн авч уулзан хоёр орны эдийн засаг, соёлын харилцааг хөгжүүлэхээр хэлэлцэн тохиролцов.

1972 оны 2-р сарын 11-нд БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн зарлиг гарч БНМАУ ба Япон улсын хооронд дайны байдлыг дуусган, 2-р сарын 19-нд Монгол Улс дайны төлбөрийн шаардлагаа зогсоож, Японтой дипломат харилцаа тогтоох болсноо зарлав. 1972 оны 9-р сард Япон улс Япон-Монголын эдийн засгийн хороо байгуулав. 1974 оны 4-р сард Монголын талын шаардлагаар Япон улс Монголд худалдааны нэн таатай нөхцөл олгов. Мөн оны 9-р сард Монгол, Японы засгийн газар, соёл, шинжлэх ухааны харилцаа тогтоох тухай ноот бичиг солилцов.

5 жилийн турш хэлэлцэн тогтсоны эцэст Монгол Улс Японы талаас 15 үйлдвэрийн газар байгуулах төслөөс татгалзаж 2 тал эдийн засгийн хамтын ажиллагааны хэлэлцээрт гарын үсэг зурлаа. Энэ бол Монгол Улс тухайн үедээ капиталист улстай байгуулсан анхны эдийн засгийн хэлэлцээр байлаа. Энэхүү хэлэлцээрээр Японы засгийн газар 17 сая ам.долларын буцалтгүй тусламж үзүүлж, Монголын нийслэл Улаанбаатарт ямааны ноолуур, тэмээний ноос боловсруулах үйлдвэр /буюу хожмын “Говь” компанийг/ байгуулахаар болсон юм. Тус үйлдвэр 1981 онд ашиглалтанд орж, жилд 1000 гаруй тн ямааны ноолуур, 200 тн тэмээний ноос боловсруулах хүчин чадалтай юм. Жилд 300 мянган ноолуурын бүтээгдэхүүн, 45 мянган тэмээний ноосон хөнжил үйлдвэрлэн, түүнийхээ 90-ээш дээш хувийг Япон, Орос зэрэг 10 гаруй оронд экспортлох болов. 1985 он гэхэд хоёр талын худалдааны нийт хэмжээ 1970 онд 1250000 ам.доллар байснаа 9.4 сая, 1989 онд 31.4 сая ам.доллар болон өсөв.

XX зууны 80-иад оноос өмнө Монгол-Японы харилцаа бага хэмжээний эдийн засгийн харилцаагаар хязгаарлагдаж байлаа. Тухайн үед Монгол Улс ЗХУ-д бүх талаар түшиглэж байсны улмаас Монгол, Японы харилцаа бодитой ахиагүй юм. Мөн зууны 90-ээд оноос хойш дэлхий дахины өөрчлөлт ба Монголын дотоод улс төрийн байдал, гадаад бодлогын өөрчлөлтөөс шалтгаалан, Монгол-Японы харилцаа улс төр, эдийн засаг, соёл, боловсрол зэрэг бүх салбарын харилцаа, хамтын ажиллагаа тасралтгүй өргөжин гүнзгийрч байна.

## **1. Монгол, Японы дээд хэмжээний айлчлал цэцэглэн хөгжиж байна**

Монгол Улс ардчилсан өөрчлөлт хэрэгжүүлснээс хойш 2 орны харилцаа хурдан хөгжиж байна. 1989 оны 5-р сард Японы Гадаад хэргийн сайд Уно Монголын урилгаар тус улсад айлчилсан явдал нь 1972 онд 2 орон дипломат харилцаа тогтоосноос хойш Японы Гадаад хэргийн сайдын Монголд хийсэн анхны айлчлал, мөн 1987 онд Монголын Гадаад явдлын яамны сайд Японд хариу айлчилсан. 2 орны Гадаад хэргийн сайд нар харилцан айлчилсны дараа Монгол-Японы дээд хэмжээний айлчлал хөгжиж эхлэв. Хоёр орны Гадаад хэргийн сайд нар 2 орны эрх зүйн үндсийг тавьсаны дараа Монгол-Японы дээд хэмжээний харилцан айлчлал хөгжиж эхэллээ.

1990 2-р сард Японы засгийн газрын урилгаар БНМАУ-ын СнЗ-ийн дарга Д.Содном Японд айлчлав. Энэ бол Монгол Улс байгуулагдснаас хойш засгийн газрын тэргүүн анх удаа албан ёсоор өрнөдийн / капиталист/ оронд хийж буй айлчлал бөгөөд 2 тал худалдааны нэн тааламжтай нөхцөл харилцан олгох хэлэлцээрт гарын үсэг зурлаа.

1991 оны 8-р сард Японы ерөнхий сайд Т.Кайфу БНМАУ-ын урилгаар айлчилсан нь мөн нэг адил өрнөдийн хөгжингүй орноос анх удаа Монголд айлчилсан явдал боллоо. Хоёр талын гарын үсэг зурсан “Монгол-Японы хамтарсан албан мэдээ”-нд тэмдэглэхдээ: “Кайфугийн Монголд хийсэн айлчлал бол хоёр орны харилцааны хөгжлийн түүхэнд бодит чухал ач холбогдолтой үйл хэрэг мөн”. Хоёр тал Монгол, Япон хоёр орны харилцааг XXI зуунд хандуулан хөгжүүлэх хэрэгтэйг тунхаглав. Ерөнхий сайд Кайфу Японы засгийн газар Монголын ардчилал, өөрчлөлт ба хоёр орны шинэ түүхэн нөхцөл дэх хамтын ажиллагааны харилцааг тууштай дэмжихээ тодорхой илэрхийлэв. Энэ удаа Японы засгийн газар Монголд 3 тэрбум иений буцалтгүй тусламж үзүүлэв.

1992 оны 5-р сард Монголын ерөнхий сайд Д.Бямбасүрэн Японд ажлын айлчлал хийж улмаар Японы зохион байгуулсан Монголд хандивлагчдын олон улсын 2-р хуралдаанд оролцов.

Тэрээр Японы ерөнхий сайдтай хэлэлцээ хийж, Японы тал энэ удаа Монголд 18 сая ам.долларын буцалтгүй тусламж үзүүлэхээр болсоны дотор 15.3 сая ам.долларын олон улсын орлого зарлагын тусламжийн фондын мөнгө багтаж байгаа ба Хятадаас 1 сая 530 мянган долларын улаан буудай, 1 сая 150 мянган долларын бордоо, хөдөө аж ахуйн тоног төхөөрөмж худалдан авах юм. Японы Гадаад хэргийн сайд энэ удаагийн Монголд хандивлагчдын олон улсын хурал дээр Монголд аль болох бололцоогоороо тусламж үзүүлэхийг олон орны төлөөлөгчдөд уриалав.

1994 оны 10-р сард Монгол Улсын УИХ-ын дарга Н.Багабанди Японд айлчилж, Японы ерөнхий сайд Багабандийг хүлээж авч уулзахдаа: “Хоёр орны харилцааг цаашид хөгжүүлэх болон хамтын ажиллагааны хүрээг өргөтгөх нь 2 орны хоорондын хамтын ажиллагаанд төдийгүй түүнчлэн бүс нутгийн хамтын ажиллагаанд идэвхтэй нөлөө үзүүлнэ” гэжээ. Багабанди хэлэхдээ: “Японтой найрсаг харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх нь Монголын гадаад бодлогын тэргүүн чиглэлийн нэг юм. Монгол Улс Японыг өөрийн Ази дахь гол түншээ гэж шууд үздэг” гэж тэмдэглэсэн байна. Хоёр тал энэ ажиллагааг 2 орны дээд хууль тогтоох байгууллагын хамтын ажиллагаанд чухал ач холбогдолтой үйл явдал боллоо хэмээн үзэж байна.

1995 оны 2-р сард Монгол Улсын Батлан хамгаалахын сайд Ш.Жадамба тэргүүтэй Монголын цэргийн төлөөлөгчид Японд айлчлав. Энэ бол Монголын дээд хэмжээний цэргийн төлөөлөгчид анх удаа Японд хийсэн айлчлал бөгөөд Японы Батлан хамгаалах танхимын даргатай уулзалт хийж 2 тал өргөн хүрээтэй салбарт хамтын ажиллагаагаа зузаатгахаа илэрхийлэв.

1998 оны 5-р сард Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Багабанди Японд төрийн айлчлал хийв. Айлчлалын хугацаанд 2 тал XXI зуунд хандсан бүх талын түншлэлийн харилцааг тодорхой хөгжүүлэх хамтарсан албан мэдээнд гарын үсэг зурлаа. Энэ нь Монгол, Японы урт хугацааны тогтвортой бүх талын түншлэлийг бий болгосны илэрхийлэл бөгөөд Монголын ерөнхийлөгчийн энэ удаагийн Японд хийсэн айлчлалын гол үр дүнгийн нэг юм. Бүх талын түншлэлийн харилцааны гол агуулга нь дараах зүйл болно. Үүнд: Хоёр орны урт хугацааны харилцааг харилцан ойлголцох ба харилцан хүндэтгэх, олон улсын харилцааны зарчимд нийцсэн, харилцан ашигтай эдийн засаг,

худалдааны түншлэлийн харилцаа, соёл боловсрол, шинжлэх ухаан техник, хүмүүнлэгийн салбарт, дэлхийн ба бүс нутгийн асуудлыг шийдвэрлэх талаар хамтран ажиллах зэрэг юм.

1999 оны 7-р сард Японы ерөнхий сайд К.Обучи Монголд 1 өдрийн албан ёсны айлчлал хийв. Энэ бол Японы ерөнхий сайдын Монголд хийж буй 2 дахь удаагийн айлчлал юм. Айлчлалын хугацаанд Японы тал 2 орны бүх талын түншлэлийн харилцааны зарчмыг дахин нотолж, улмаар Японоос 1999 онд үзүүлэх соёлын буцалтгүй тусламжийг Монгол Улсын соёлын өвийн төвд тоног төхөөрөмж нийлүүлэхэд зориулан ашиглах баримт бичигт гарын үсэг зурав. Мөн Монголын үр тарианы үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, хүнсний бүтээгдэхүүнийг боловсруулах түвшинг сайжруулах “KAIR 2” төслийн баримт бичиг ба Улаанбаатар хотноо Японы соёлын төв байгуулах хэлэлцээр зэрэг чухал баримт бичигт гарын үсэг зурлаа.

2001 оны 2-р сард Монголын ерөнхий сайд Н.Энхбаяр Японд 1 долоо хоногийн албан ёсны айлчлал хийв. Энэ бол Энхбаяр ерөнхий сайдаар сонгогдсоныхоо дараах анхны гадагш хийсэн айлчлал юм. Айлчлалын хугацаанд Монголын ерөнхий сайд Японы талд Монголын шинэ засгийн газар Японтой урт хугацааны тогтвортой, бүх талын түншлэлийн харилцааны гадаад бодлогыг тууштай хэрэгжүүлэн явуулахаа илэрхийлэв. Японы тал Монголыг урьдын адил дэмжиж, Монголд үзүүлэх эдийн засгийн тусламжаа багасгахгүй гэдгээ дахин нотлов.

Сүүлийн жилүүдэд Монгол, Японы гадаад харилцааны салбарын хамтын ажиллагаа илтэд сайжрав. 2004 оны 8-р сард Японы Гадаад хэргийн сайд Монголд айлчилж, Монголын ерөнхийлөгч, ерөнхий сайд нартай тус бүр уулзаж, Монгол Улсын Гадаад хэргийн сайд Л.Эрдэнэчулуунтай уулзалт хийв. Энэ удаа Монголын тал Японд дэлхийн 2-р дайны дараа олзлогдсон хүний Монгол дахь 10100 япон хүний материалыг өгч, Японы тал Монголын ШУА-ийн Археологийн хүрээлэнд 400 мянган ам.доллар ба Монголын морин хуурын өвийг хамгаалж сурталчилахад 150000 ам.долларын тусламж үзүүлэв. 2005 оны 3-р сард Монголын Гадаад хэргийн сайд Ц.Мөнх-Оргил Японд айлчилж, Ерөнхий сайд Ж.Коизуми, Гадаад хэргийн сайд нар тус бүр түүнийг хүлээн авч уулзав. Японы тал Монгол Улсын улс төр, эдийн засгийн өөрчлөлт шинэчлэлтийг үргэлжлэн дэмжихээ илэрхийлж, Японоос хойшдын 5 жилд Монголд үзүүлэх тусламжийн төслийг тогтоож, энэ удаа хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг сайжруулахад 200 сая иений буцалтгүй тусламж үзүүлэхээ амлав.

2005 оны 7-р сарын 14-нд Улаанбаатарт Монгол, Японы ГХЯ-ны бодлого зохицуулалтын уулзалт болов. Хоёр тал 1996 оны оноос ийм уулзалтыг 6 удаа хийсэн юм. Энэ удаагийн уулзалтаар 2003 оноос хойшхи Монгол, Японы харилцааг нэгтгэн дүгнээд 2005-2006 онд 2 орны харилцааны чиглэл, бодитой хэрэгжүүлэх арга зам, бүс нутгийн асуудал хийгээд олон талт хамтын ажиллагааны талаар санал солилцлоо. Монгол Улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Гадаад хэргийн сайд нар Японы Гадаад хэргийн яамны төлөөлөгчдийг тус тус хүлээн авав. Японы тал Япон улс Монголын улс төр, эдийн засгийн шинэчлэлт ба нийгмийн хөгжлийг дэмжиж, цаашидч урьдын нэг адил дэмжихээ илэрхийлж Японы засгийн газрын хөгжлийн тусламж үзүүлэх төлөвлөгөөг танилцуулав. Хоёр тал хоёр орны дээд хэмжээний уулзалтыг хадгалан хоёр орны эдийн засаг, худалдаа хөрөнгө оруулалтыг хурдасгах, соёлын болон иргэдийн солилцоог өргөтгөхөөр хэлэлцэн тогтлоо.

Японы тал НҮБ-ын шинэчлэл ба Япон улс Аюулгүйн Зөвлөлийн Байнгын гишүүнээр элсэх байр сууриа тодорхойлж, Монгол Улс Японыг Аюулгүйн Зөвлөлд элсэхэд тууштай дэмжиж байгаад талархаж, Японы тал Монголыг Ази, Номхон далайн олон талт хамтын ажиллагаанд оролцохыг дэмжихээ илэрхийлэв.

2006 оны 1-р сарын 28-нд албан тушаалдаа орсон Монгол Улсын шинэ Ерөнхий сайд М.Энхболд Японы засгийн газрын урилгаар 3-р сарын 26-30-нд Японд албан ёсны айлчлал хийлээ. Энэ бол түүний ерөнхий сайд болсноос хойшхи анхны гадагш хийсэн айлчлал юм. Японы Ерөнхий сайд Ж.Коизуми Монгол Улсын Ерөнхий сайд М.Энхболдыг хүлээн авч уулзан, хоёр тал хоёр орны улс төр, эдийн засаг, соёл зэрэг бүхий л салбарт хамтын ажиллагааг зузаатгах талаар ярилцаж, Япон-Монголын бүх талын түншлэлийн харилцааг бэхжүүлэх зэрэг асуудлаар хэлэлцэн тогтов.

Олны анхаарлыг татаж буй нэг зүйл бол энэ удаагийн Монгол Улсын Ерөнхий сайд М.Энхболд Японд айлчлахдаа онгоцноос шууд буугаад Японы Сумогийн ордонд очиж Японы сумогийн цорын ганц их аварга Монголын сумоч Д.Дагвадоржид шагнал гардуулсан явдал юм. Энэ тэмцээнд эхний 3 байранд орсон сумочид бүгд монгол хүн байлаа. Японы засгийн газар ийнхүү “Сумогийн тэмцээн” үзүүлэхээр зохион байгуулсан нь тэмцээний сайхан сэтгэгдэл Япон, Монголын найрсаг харилцааны уур амьсгалыг бий болгох, Японы тал Монголын Ерөнхий сайдын анхны айлчлалд чухал ач холбогдол өгч Монголд найрсагаар ханддагийн тусгал болсон юм.

Дээр дурдсан бүхий л дээд хэмжээний харилцан айлчлал ба гарын үсэг зурсан хэлэлцээрүүд нь Монгол-Японы харилцааг тогтвортой хөгжүүлэхийн тулд улс төрийн үндэс суурь, хууль эрхийн баталгааг бий болгож, Монгол-Япон хоёр орны бүх талын иж бүрэн түншлэлийг бий болгож, хөгжүүлэхэд идэвхтэй үзүүлэх ач холбогдолтой юм.

## **2. Японоос Монголд үзүүлж буй тусламж**

Монголын шилжилт эдийн засгийн бэрхшээлтэй учирч буй үед Япон өгөөмөр хандаж олон төрлийн эдийн засгийн тусламж үзүүллээ. 1991 оноос 2004 он хүртэл Японоос Монголд 128 тэрбум 280 сая иений эдийн засгийн тусламж өгсөн нь Монголын гадаадын нийт зээл ба тусламжийн 70% нь болж байна. Япон улс жилд дунджаар Монголд 100 сая ам.долларын тусламж, түүний дотор 45-50 сая ам.долларын хөнгөлөлттэй зээл, 30-50 сая ам.долларын буцалтгүй тусламж, 10 сая гаруй ам.долларын шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны тусламж үзүүлж байна. Японы Гадаад хэргийн яамны материалаас үзвэл 2005 оны санхүүгийн жилд Монгол Улс Японы засгийн газраас 4 удаа нийт 1 тэрбум 484 сая иений хөгжлийн тусламж авсаны дотор бага орлоготой тариачдад 330 сая иен, Монголын зүүн аймгуудын замыг сэргээн засах, шинээр барихад 544 сая иен, хүний нөөцийн шагналд 407 сая иен, үр тариа авахад 200 сая иений тусламж үзүүлсэн байна. 2006 оны санхүүгийн жилд Япон улс “өвсний үндэс” хөтөлбөрийн хүрээнд Монголд 2.4 ам.долларын 36 төслийн буцалтгүй тусламж, түүний дотор 22 төслийг боловсрол соёлын салбарт хэрэгжүүлнэ. Тус төслийн онцлог бол тусламжийн мөнгө засгийн газраар дамжихгүй шууд хэрэгжиж буй төслийнхөө заасан газарт очих юм. Японоос Монголд хэрэгжүүлж буй “өвсний үндэс” төсөл хэрэгжээд нэгэнт 16 жил болжээ. Япон улс 1997 оноос гадаад орнуудад тусламжийн бэлэн мөнгөө багасгаж эхэлсэн боловч үнд Монгол Улсыг хамруулаагүй юм. Одоо Япон дэлхийн 160 улсад төрөл бүрийн эдийн засгийн тусламж үзүүлж байгаагийн дотор Монголд өгч буй буцалтгүй тусламж нь 17-р байрт, хөнгөлөлттэй зээл нь 36-р байрт явж байгаа ба Монгол Улс Японоос 1 хүнд дунджаар ноогдох тусламжийн хэмжээгээр дэлхийд 1-рт орж байна.

Япон улс мөн олон улсын байгууллага ба хандивлагч орнуудаас Монголд тодорхой хугацаанд тусламж үзүүлэх ажлыг дайчлан зохион байгуулж байна. 1991-2003 онд Японы Засгийн газар ба Дэлхийн Банк зэрэг олон улсын байгууллага толгойлон Монголд хандивлагчдын олон улсын хурлыг нийт 10 удаа хийгээд байгаа ба Монголд бараг 3.6 тэрбум

ам.долларын хөнгөлөлттэй зээл ба буцалтгүй тусламж үзүүлэхээ амлаад байна. Энд Япон улсын амласан тусламжийн хэмжээ, бодитойгоор туслаж буй хөрөнгө мөнгө хамгийн их бөгөөд тусламжийн нийт хэмжээний 40-өөс дээш хувийг эзэлж байна.

Япон улсаас Монголд үзүүлж буй тусламж нь гамшигт туслах, эм, хүнсний бүтээгдэхүүн ба дэд бүтцийг хөгжүүлэхэд зориулж 2 жилийн дотор 4.5 тэрбум иений эмнэлгийн тоног төхөөрөмж, эм, хүнсний бүтээгдэхүүн нийлүүлжээ. 1991 оноос эхэлж Япон улс жил бүр Монголд нийлүүлсэн үр тарианы тусламжийн нийт өртөг 25 сая ам.доллар болжээ. Японы засгийн газар “хүнсний бүтээгдэхүүний баталгааг сайжруулах КР-1 төсөл”-өөр дамжуулан Монголд улаан буудай нийлүүлэх, уг төслийн дагуу Монголд 11 удаа 900 сая иений өртөг бүхий тусламж үзүүлэх ажээ.

Японоос Монголд үзүүлж буй буцалтгүй тусламжийн бүтээн байгуулалтын үндсэн арга хэмжээ гэвэл: Улаанбаатарын авто замын сүлжээнд зориулж 60 том оврын машин, 16 сая ам.долларын хөрөнгө оруулалтаар нийслэлийн авто замыг сайжруулах төсөл, 1399 тэрбум иений хөрөнгө оруулалттай төмөр замыг сэргээн засах төсөл, Монголдоо нэлээд томд тооцогдох Шивээ Овоо нүүрсний уурхайд 7.7 тэрбум иений техник тоног төхөөрөмж нийлүүлэх, Говийн эрчим хүчний системд холбогдоогүй хөдөө нутагт цахилгаан эрчим хүч хүргэх ба хамгаалахад зориулж Япон улс Монголын 144 суманд өндөр үр ашигтай дизель цахилгаан станц суурилуулах, хөдөө аж ахуйд хэрэглэгдэх машин механизм нийлүүлэх ба малчдад худаг гаргахад туслана. Японы бүтээн байгуулалтын тусламжийн том төслүүд нь гэвэл: Монголын түүхэн дэх анхны төмөрлөгийн үйлдвэр буюу Дарханы төмөрлөгийн үйлдвэрийг зээлийн мөнгөөр сэргээн засварласнаар Монгол Улсын ган үйлдвэрлэдэггүй байсан түүх эцэс болно. Монголын хамгийн том цахилгаан станц буюу Улаанбаатарын 4-р дулааны цахилгаан станц ба тусгайлан энэ станцад нүүрс нийлүүлдэг Багануурын нүүрсний ил уурхайг засаж сайжруулах, нийслэлд байнга цахилгаан тасардаг бэрхшээлт байдлыг арилгана. Хятадын Эрээн хотын боомтын нөгөө талд байх Замын-Үүдийн галт тэрэгний өртөөг өргөтгөн, Монголын төмөр замын дотоодын болон олон улсын тээвэрлэх чадварыг сайжруулна. Мөн Монгол Улсын клиникийн 2-р эмнэлгийн тоног төхөөрөмжийг шинэчлэн, Улаанбаатарын ус хангамжийн системийг өөрчлөн засаж Монгол Улстай хамтарсан хөрөнгө оруулалттай 200 мянган хэрэглэгч бүхий Монголын хамгийн том хөдөлгөөнт холбооны компани /Мобиком/ зэргийг байгууллаа.



### **3. Монгол, Японы эдийн засаг худалдааны харилцаа**

1990 онд байгуулсан Япон, Монголын худалдааны хэлэлцээрээс хойш 2 орны эдийн засаг, худалдааны харилцаа тодорхой хөгжилд хүрлээ. Сүүлийн жилүүдэд 2 талын эдийн засаг, худалдаа аажмаар өслөө. Монголын гадаадын хөрөнгө оруулалтын газрын мэдээгээр одоо Монголд Японы хөрөнгө оруулалттай 164 аж ахуйн газар байгаа ба шууд хөрөнгө оруулалт нь 68599 сая ам.долларт хүрч гадаадаас Монголд хөрөнгө оруулсан орнуудын дотор 5-р байр эзэлж байна. Японд Монголын хөрөнгө оруулалттай аж ахуйн газар байхгүй юм.

Монгол Улсын статистикийн материалаас үзэхэд Монгол, Японы 2 талын худалдаа 1990 онд 17.4 сая ам.доллар байснаасаа 1999 онд хамгийн их өсч 125,9 сая ам.долларт хүрч 7 дахин нэмэгджээ.

Харин цаашид буурч 2002 он болоход 49.1 сая ам.доллар, 2004 онд дахин өсч 1079 сая ам.долларт хүрэв.

2004 онд Монгол Улс Японоос 74.5 сая ам.долларын бараа импортлож, Японд 33.5 сая ам.долларын бараа экспортлов. Монголоос Японд голлон боловсруулаагүй буюу хагас боловсруулсан алт, мал аж ахуйн төрөл бүрийн бүтээгдэхүүн, архи, жоншны баяжмал, зэсийн баяжмал, бэлэн хувцас гэх мэтийг экспортлодог. Японоос голлон төрөл бүрийн цахилгаан багаж төхөөрөмж, холбооны хэрэгсэл, барилгын материал, үйлдвэрийн тоног төхөөрөмж, үр тариа, гурил, гурилан бүтээгдэхүүн, ургамлын тос, элсэн чихэр, пиво, тамхи, эм, будаг, нүүр гарын саван болон өдөр тутмын хэрэглээний бараа бүтээгдэхүүнийг импортлодог. Одоо Монгол, Японы худалдааны хэмжээ Хятад, Орос, Америк, Английн дараа 5-рт орж байна. Монголын талын задлан шинжилснээр Монгол, Японы худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаа долгионтой байгаагийн шалтгаан нь 2 орны хооронд зам тээвэр таагүй гэсэн гол шалтгаанаас гадна Монголын талын бараа бүтээгдэхүүний чанартай ихээхэн холбоотой аж. Үүнээс гадна Хятадаас их хэмжээгээр импортлож буй өдөр тутмын хэрэглээний барааны үнэ хямд. Энэ нь Монголын дундаас доош амьдралын түвшинтэй ард иргэдийн эрэлт шаардлагад их нийцдэгийн улмаас Японы чанар сайтай өдөр тутмын хэрэглээний бараа Монголын зах зээл дээр давуу байдлаа алдаж байна.

### **4. Монгол, Японы боловсролын хамтын ажиллагаа, соёлын солилцоо идэвхтэй хөгжиж байна**

Монголын шилжилтийн үеэс хойш Монгол, Япон хоёр орны соёлын солилцоо ба боловсролын хамтын ажиллагаа аажмаар

өргөжлөө. Япончууд эдийн засгийн тусламжаас гадна соёл, боловсролын хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлэх нь сая Монголын ард түмний сэтгэл санаанд гүн гүнзгий нөлөөлнө гэдгийг мэдэж байгаа.

1990 оноос хойш жил бүр Японд Монголын оюутан, мэргэжил дээшлүүлэгч, богино хугацааны шинжлэх ухааны солилцоогоор ажиллагч эрдэмтэд 200 гаруй болж, 2004 он гэхэд энэ тоо 500-д хүрсэн бөгөөд зардлын ихэнх хэсгийг Японы тал хариуцаж байгаа юм. Японы талаас Монголын их дээд сургуульд монгол хэл, монгол соёл, урлаг хийгээд ёс заншлыг нь судлах улсын ба хувийн зардлаараа суралцагчдыг жил бүр 10 гаруйг явуулж байна. 2002 оноос эхлэн “Өвсний үндэс” хөтөлбөр хэрэгжүүлж тусламжийн гол чиглэлээ эдийн засгаас аажмаар соёлын салбарт шилжүүлэв. 2002 оны 6-р сард Японы засгийн газраас санхүүжүүлсэн 4 тэрбум төгрөгний /ойролцоогоор 3.4 сая ам.доллар/ тусламжаар Монгол, Японы соёлын төвийг МУИС-ийн дэргэд байгуулав. Тус төв залуучуудад лекц унших, япон кино үзүүлэх, япон хэлний сургалт явуулах зэрэг үйл ажиллагааг тодорхой хугацаанд үнэ төлбөргүй явуулах юм. Одоо энэ соёлын төв Монголын олон түмэнд Японыг ойлгох, япон хэлийг сурах гол газар болж байна. 2001 онд Японы засгийн газар Улаанбаатар хотод буцалтгүй тусламжаар 6 бага сургууль барьж, мөн Японы засгийн газраас “Монголын багш нарыг бэлтгэх төлөвлөгөөний төсөл” зохиож уг төлөвлөгөөгөөр жил бүр Монголын 10 багшийг Японд мэргэжил дээшлүүлж байна. 2003 оноос эхлэн Японы засгийн газар боловсролд хөрөнгө оруулах ажлыг нийслэл Улаанбаатараас хөдөөд, ялангуяа ядуу бэрхшээлтэй аймаг суманд шилжүүлэв. Мөн жилд Монголын 21 аймгийн төвд Японы “Өвсний үндэс” төслийн нийт 1.5 сая ам.долларын хөрөнгө оруулалтын тусламж хүртсэн сургууль 70-аас доошгүй байв.

2004 онд “Өвсний үндэс” төслийн хүрээнд 2 тэрбум төгрөгийн өртөг бүхий 25 төсөл хэрэгжүүлсний дотор дунд бага сургуулийн дотуур байр, хүүхдийн цэцэрлэг, эмнэлгийг өргөтгөх, засах, барих ажил хамрагдаж байгаа ба тахир дутуу хүмүүст материаллаг тусламж үзүүлэх, сургуульд компьютер, DVD, өнгөт телевизор бэлэглэх, хөдөөгийнхөнд цахилгаан үүсгүүр, трансформатор, ус дамжуулах хоолой, бохир ус цэвэрлэх систем нийлүүлэх зэрэг хөтөлбөр багтаж байна. 2004 оны эцэс гэхэд Монголд суугаа ЭСЯ Японоос Монголд суугаа олон улсын хамтын ажиллагааны газар ба Монголын засгийн газар, Азийн Банк, Дэлхийн Банк зэрэг байгууллагатай хамтран 19 тэрбум төгрөгийн хөрөнгө гаргаж Монголын 308 боловсролын байгууллагыг засаж,

өргөтгөн барих ажил хийлээ. 2005 оны 9-р сарын эхээр Японы засгийн газар Монголын засгийн газарт бас дахин 50 сая иений өртөг бүхий Монголын хөгжим бүжгийн сургуулийг шинэчлэн тоноглох соёлын салбарын будалтгүй тусламж үзүүлж, Японоос Монголд суугаа элчин сайд ба Монгол Улсын Гадаад хэргийн сайд Ц.Мөнх-Оргил нар гарын үсэг зурах ёслолд оролцов. 1984 оноос хойш Японоос Монголд 17 удаа соёлын тусламж өгсөний мөнгөн дүн нь 713.3 сая иен болжээ.

Японы засгийн газрын бус байгууллага ч бас Монголд соёл боловсролын тусламжийн үйл ажиллагааг идэвхтэй өрнүүлж байна. Японы олон улсын хамтын ажиллагааны хэрэг эрхэлсэн бүлэг Улаанбаатар хот, Говь-Алтай аймаг, Мөрөн хотод шугамгүй цахилгаан богино долгионы төв байгуулав. Японы “Монгол түнш” байгууллага хөдөөгийн сургуулиудад 250 самбар бэлэглэжээ.

Японы “Энх тайвны салхи” засгийн газрын бус байгууллагаас Монголд суугаа элчин сайд нар 2004 онд Японы “Засгийн газрын бус байгууллагыг дэмжих буцалтгүй тусламжийн” хүрээнд хэрэгжүүлж буй “хурууны хээ тавих төхөөрөмж, сургуулийн үйл ажиллагааг урамшуулах” төслийн хэлэлцээрт гарын үсэг зурав. Хэлэлцээр ёсоор тус байгууллага Монголын Боловсрол, соёл, шинжлэх ухааны Яамтай хамтран Өмнөговь, Дундговь аймгийн 15 сургуульд 24000 ам.долларын тоног төхөөрөмж нийлүүлэх юм.

Сүүлийн жилүүдэд Монгол, Япон хоёр орон жил бүр соёлын өдрүүдийн үйл ажиллагааг харилцан зохиож байна. Монголд зохиосон “Японы соёлын өдөр”-ийн үйл ажиллагаа нь Монголын олон нийт Японы түүх, соёл, нийгэм, эдийн засгийн хөгжлийг ойлгоход нэн сайн гүүрийн үүрэг гүйцэтгэсэн юм.

2005 оны 5-р сард Японы тал хөрөнгө гарган зохион байгуулсан Монголын соёлын өдрийн үйл ажиллагааны үеэр Монголын урлагийнхан монгол ардын уртын дуу, ардын дуу, хөөмий, бүжиг, морин хуур болон үндэсний хөгжмийн тоглолт зэрэг Монголын уламжлалт соёл урлагийн наадмыг үзүүлсэн нь Японы олон нийтийн халуун талархлыг хүлээсэн юм. Хоёр орны соёлын солилцоог цаашид гүнзгийрүүлэхийн тулд Японд 2006 оныг “Монголын жил” болгож 2007 онд Монгол, Японы дипломат харилцааны 35 жилийн ойг тэмдэглэх, Япон улс Монголд “Японы жил”-ийг зохион байгуулах үйл ажиллагаа явуулах юм.

Биеийн тамирын талаар, Монгол, Япон улс сумо бөхөөр хамтран ажиллаж мэдэгдэхүйц амжилт олж байна. Хэдхэн жилийн дотор Японы монгол сумочдын техник, арга чадал япончуудыг даван гарч, 1999 онд Японы сумогийн ертөнцөд Монголын сумоч Асашёрю Д.Дагвадорж

ердөө 25 башё барилдаж хамгийн дээд цол ёкозуна цол хүртэн Японы сумогийн 68 дахь их аварга болсон юм. Тэрээр одоо Японы цорын ганц ёкозуна цолтон юм. Үүнээс хойш монголчууд Японы сумогийн тэмцээнд оролцох сонирхол эрс ихэссэн юм. 2006 оны 3 сарын сумогийн тэмцээнд монгол сумочид бүхий л тэргүүн байруудыг эзэлсэн юм. Улмаар Японы сумогийн ордонд монгол бөх, сумо бөхийн хамтын ордон болжээ.

Монгол, Японы харилцааг хөгжүүлэх нь аль аль талын хэрэгцээ юм.

Хүйтэн дайны дараа Монгол Улс улс орныхоо аюулгүй байдлыг харгалзах, гадаад бодлогын стратегидаа ихээхэн зохицуулалт хийж, практик арга хэмжээ авч, уян хатан “олон тулгуурт” гадаад бодлого явуулж “их гүрнүүдтэй тэнцвэртэй хандах дипломат бодлого” хэрэгжүүлж байна. Өөрөөр хэлбэл Орос, Хятад хоёр том хөрш оронтойгоо найрсаг харилцаагаа тэнцвэртэй хөгжүүлэхийн зэрэгцээ Америк, Японыг голлон өрнөдийн орнуудтай харилцаагаа идэвхтэй хөгжүүлж байна.

Монгол Улс Америк, Япон болон Хятад, Оростой тогтоосон харилцаандаа түшиглэн улсынхаа аюулгүй байдлыг хангахыг эрмэлзэж байгаа бол эдийн засгаа сэргээхэд хөрөнгө мөнгө, техник олж авахыг чармайж байна. Түүнчлэн Японы зорилго бол:

1. Япон улс ХХ зууны 80-аад оноос эхлэн “Зүүн Азийн эдийн засгийн хамтын ажиллагаа”-г аажмаар Японы тодорхой чиглэл боллоо. БНХАУ, Ардчилсан Солонгос, БНСУ, Монгол зэрэг Зүүн Азийн эдгээр орны дотор Монгол бол Японд нөлөө үзүүлэх хамгийн бага улс юм. Хэрвээ Монголоос өө сэвийг нь гаргаж чадвал Зүүн Азийн эдийн засгийн хамтын ажиллагааг урагшлуулахад эдийн засаг, улс төрийн салбарт эзлэж буй Зүүн Азийн хамтын ажиллагааны ноёлох өндөрлөгт чухал ач холбогдолтой юм.

2. Япон Монголын яаралтай шаардагдаж буй гадаад хөрөнгө оруулалтын боломжийг баяртайгаар гүйцэтгэж буйн зорилго нь Монголын эдийн засагт өргөнөөр нөлөөлөх, Монголд эзэн байх эрхийг олж авах, Монголын байгалийн баялгийг нээн ашиглах урьдчилсан бэлтгэлд оролцохын төлөө юм.

*Хятад хэлнээс орчуулсан Л.Бэгзжав*